



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/10

Улаанбаатар хот

Хөрөнгө хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Эрх шилжүүлэх тухай” А/1384 дүгээр захирамж, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Урт цагаан үйлчилгээний төвийн буулгаж байгаа барилгын түр хашааг НХААГ/202312399 дугаартай гэрээний дагуу “Өнө Гэрэгэ Констракшн” ХХК-аас нийлүүлэх тул тус хөрөнгийг хяналт тавьж, хүлээн авах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Дээрх хашааг тендерийн баримт бичиг, ажлын даалгаврын дагуу хүлээж авах ажлыг зохион байгуулахыг Ажлын хэсэг (М.Энхболд)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (М.Мөнхбаяр)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500033

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2024 оны 02 дугаар сарын 06 -ний өдрийн
А/10 дугаар тушаалын хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:	М.Энхболд	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн менежментийн хэлтсийн дарга
Гишүүд:	Ж.Сувданзаяа	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтсийн Ахлах мэргэжилтэн
	Д.Батбаяр	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нярав
	Б.Амарзаяа	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Аж ахуй хариуцсан Ахлах зохион байгуулагч
Нарийн бичгийн дарга:	О.Уранчимэг	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн